

ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын эрүүл мэндийн төвийн
2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2025/103/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Мөрөн сум

2025 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Аудитор: Г.Ичинхорлоо

Утас:88688168 Цахим хаяг: ichinkhorloog@audit.gov.mn

Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн захирал Б.Мядагмаа

Утас:99389208 Цахим хаяг: b_myadagmaaa@yahoo.com

Аудитор Ц.Мөнхтуяа

Утас: 99382220 Цахим хаяг: munkhtuya2220@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 1/185

танай _____-ны № _____-т

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тосонцэнгэл сумын эрүүл мэндийн төв нь тайлант онд Эрүүл мэндийн даатгалын сангаас 1,059,922.9 мянган төгрөгийн санхүүжилтийг авахаас гүйцэтгэлээр 904,689.8 мянган төгрөгийг санхүүжилтийг авч, үлдэгдэл 155,233.1 мянган төгрөгийг авлагаар бүртгэсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар нийт 24,246.5 мянган төгрөгийн 9 алдаа, зөрчлийг илрүүлснээс 14,195.3 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 7,109.2 мянган төгрөгийн 6 зөрчилд зөвлөмж өгч, 2,942.0 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

Бусад асуудлын хэсэг

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас Тосонцэнгэл сумын эрүүл мэндийн төвтэй байгуулсан анхан шатны тусламж үйлчилгээг худалдан авах 2024 оны гэрээний биелэлтийг 83.6 хувьтай дүгнэсэн байна.

6703821382

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А ЗРДЭНЗБААТАР



Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	313,434,301.21	374,979,708.05
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	163,553,163.61	96,009,142.37
312	Банканд байгаа бэлэн мөнгө	163,553,163.61	96,009,142.37
3121	Төгрөг	163,553,163.61	96,009,142.37
31211	Төрийн сангийн харилцах	163,553,163.61	96,009,142.37
33	АВЛАГА	14,195,329.00	155,233,138.13
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	14,195,329.00	155,233,138.13
35	БАРАА МАТЕРИАЛ	135,685,808.60	123,737,427.55
351	Түүхий эд материал	92,359,273.70	59,654,511.23
35130	Эм боох материал	92,359,273.70	59,654,511.23
354	Хангамжийн материал	43,326,534.90	64,082,916.32
35410	Бичиг хэргийн материал	754,070.00	1,098,510.00
35420	Аж ахуйн материал	36,026,248.00	47,219,915.06
35440	Түлш, шатах тослох материал	2,266,000.00	4,149,900.00
35450	Барилгын засварын материал	0.00	4,300,000.00
35460	Хүнсний материал	3,256,716.90	4,668,591.26
35470	Бусад хангамжийн материал	1,023,500.00	2,646,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	293,054,044.24	2,204,160,464.14
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	293,054,044.24	2,204,160,464.14
392	Биет хөрөнгө	280,807,710.72	2,192,105,130.54
39201	Барилга, байгууламж, орон сууц	80,657,287.10	1,752,615,947.10
39202	Хуримтлагдсан элэгдэл	(54,161,053.09)	(60,824,384.17)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	61,484,000.00	61,484,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(27,317,225.06)	(36,317,358.38)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	253,387,866.13	548,266,121.78
39206	Хуримтлагдсан элэгдэл	(95,494,391.75)	(139,752,672.08)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	58,884,793.00	65,624,793.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(19,743,333.92)	(26,341,799.78)
39214	Бусад үндсэн хөрөнгө	33,262,894.51	39,882,894.51
39215	Хуримтлагдсан элэгдэл	(10,153,126.20)	(12,532,411.44)
393	Биет бус хөрөнгө	12,246,333.52	12,055,333.60
39301	Программ хангамж	955,000.00	955,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(418,666.48)	(609,666.40)
39303	Бусад биет бус хөрөнгө	11,710,000.00	11,710,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	606,488,345.45	2,579,140,172.19
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	606,488,345.45	2,579,140,172.19
51	Засгийн газрын хувь оролцоо	606,488,345.45	2,579,140,172.19
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	243,350,497.80	243,350,497.80
51101	Өмч: - төрийн	243,350,497.80	243,350,497.80
512	Хуримтлагдсан үр дүн	258,589,257.55	2,231,241,084.29
51210	Өмнөх үеийн үр дүн	258,589,257.55	258,589,257.55
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	1,972,651,826.74
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	104,548,590.10	104,548,590.10
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	606,488,345.45	2,579,140,172.19

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	866,098,662.24	3,209,555,904.18
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	63,860,170.27	2,094,217,065.23
120	Нийтлэг татварын бус орлого	63,860,170.27	2,094,217,065.23
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	63,860,170.27	2,094,217,065.23
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,000,000.00	88,337,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-үндсэн хөрөнгө	43,860,170.27	2,005,880,065.23
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	802,238,491.97	1,115,338,838.95
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	65,388,900.00	69,611,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	65,388,900.00	69,611,300.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	736,849,591.97	1,045,727,538.95
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	736,849,591.97	1,045,727,538.95
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	888,802,125.51	1,236,904,077.44
21	УРСГАЛ ЗАРДАЛ	888,802,125.51	1,236,904,077.44
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	888,762,124.23	1,178,150,697.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	489,949,950.00	694,625,427.00
210101	Үндсэн цалин	324,695,152.00	397,596,082.00
210102	Нэмэгдэл	113,812,425.00	209,159,327.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,695,000.00	19,255,000.00
210104	Урамшуулал	44,747,373.00	68,615,018.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	61,924,405.00	86,627,562.96
210201	Тэтгэврийн даатгал	42,763,861.82	59,133,467.80
210202	Тэтгэмжийн даатгал	5,031,042.38	6,994,038.62
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,923,633.93	3,467,320.08
210204	Ажилгүйдлийн даатгал	926,640.36	3,391,113.90
210205	Эрүүл мэндийн даатгал	9,279,226.51	13,641,622.56
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	62,348,898.72	62,359,920.00
210301	Гэрэл, цахилгаан	5,159,998.72	5,761,520.00
210302	Түлш, халаалт	55,598,400.00	55,598,400.00
210303	Цэвэр, бохир ус	1,590,500.00	1,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	39,323,836.63	64,827,972.62
210401	Бичиг хэрэг	4,346,600.00	3,898,660.00
210402	Тээвэр, шатахуун	13,352,340.00	10,943,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,635,361.00	2,799,018.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,360,000.00	2,362,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,629,535.63	16,828,758.00
210408	Бараа материал акталсны зардал	0.00	27,995,436.62
2105	Норматив зардал	126,526,664.16	120,113,807.11
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	109,604,785.76	100,608,387.47
210502	Хоол, хүнс	16,921,878.40	14,030,419.64
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	5,475,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,390,000.00	22,396,900.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	6,000,000.00	0.00
210604	Урсгал засвар	10,390,000.00	22,396,900.00
2107	Томилот, зочны зардал	2,080,000.00	7,083,400.00
210702	Дотоод албан томилот	2,080,000.00	7,083,400.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,897,396.00	27,295,632.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,268,800.00	23,649,624.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,152,000.00	1,152,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	129,000.00	129,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	131,936.00	241,756.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.00	55,000.00
210807	Газрын төлбөр	35,130.00	35,132.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,125,530.00	2,033,120.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	84,320,973.72	92,820,075.75
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,198,700.00	9,139,580.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	71,122,273.72	83,680,495.75
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	40,001.28	58,753,380.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	58,302,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.00	58,302,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	40,001.28	451,380.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	40,001.28	451,380.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(22,703,463.27)	1,972,651,826.74
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.00	0.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	56,250.00	0.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(56,250.00)	0.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(22,759,713.27)	1,972,651,826.74

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	808,043,162.97	1,062,638,029.82
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	20,000,000.00	88,337,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	20,000,000.00	88,337,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	20,000,000.00	88,337,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	0.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,000,000.00	88,337,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	788,043,162.97	974,301,029.82
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	65,388,900.00	69,611,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	65,388,900.00	69,611,300.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	722,654,262.97	904,689,729.82
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	722,654,262.97	904,689,729.82
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	755,162,334.00	1,109,682,051.06
21	УРСГАЛ ЗАРДАЛ	755,162,334.00	1,109,682,051.06
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	755,122,332.72	1,050,928,671.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	489,949,950.00	694,625,427.00
210101	Үндсэн цалин	324,695,152.00	397,596,082.00
210102	Нэмэгдэл	113,812,425.00	209,159,327.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,695,000.00	19,255,000.00
210104	Урамшуулал	44,747,373.00	68,615,018.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	61,924,405.00	86,627,562.96
210201	Тэтгэврийн даатгал	42,763,861.82	59,133,467.80
210202	Тэтгэмжийн даатгал	5,031,042.38	6,994,038.62
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,923,633.93	3,467,320.08
210204	Ажилгүйдлийн даатгал	926,640.36	3,391,113.90

210205	Эрүүл мэндийн даатгал	9,279,226.51	13,641,622.56
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	62,348,898.72	62,359,920.00
210301	Гэрэл, цахилгаан	5,159,998.72	5,761,520.00
210302	Түлш, халаалт	55,598,400.00	55,598,400.00
210303	Цэвэр, бохир ус	1,590,500.00	1,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	32,419,192.00	33,528,420.00
210401	Бичиг хэрэг	3,498,400.00	4,129,850.00
210402	Тээвэр, шатахуун	11,550,000.00	12,827,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,635,361.00	2,799,018.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,360,000.00	4,235,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,375,431.00	9,537,052.00
2105	Норматив зардал	69,235,621.00	97,361,079.10
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	54,645,490.00	74,520,085.10
210502	Хоол, хүнс	14,590,131.00	15,365,994.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	7,475,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,990,000.00	31,171,900.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	6,000,000.00	4,475,000.00
210604	Урсгал засвар	11,990,000.00	26,696,900.00
2107	Томилолт, зочны зардал	2,080,000.00	7,083,400.00
210702	Дотоод албан томиллолт	2,080,000.00	7,083,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,053,566.00	27,408,882.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,268,800.00	23,649,624.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,152,000.00	1,152,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	129,000.00	129,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	131,936.00	241,756.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.00	55,000.00
210807	Газрын төлбөр	35,130.00	35,132.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,281,700.00	2,146,370.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,120,700.00	10,762,080.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,120,700.00	10,762,080.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	40,001.28	58,753,380.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	58,302,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.00	58,302,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	40,001.28	451,380.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	40,001.28	451,380.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	52,880,828.97	(47,044,021.24)
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	0.00	0.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	27,400,000.00	20,500,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	27,400,000.00	20,500,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	27,400,000.00	20,500,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	27,400,000.00	20,500,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(27,400,000.00)	(20,500,000.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	25,480,828.97	(67,544,021.24)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	138,072,334.64	163,553,163.61
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	163,553,163.61	96,009,142.37

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	243,350,497.80	104,548,590.10	281,348,970.82	629,248,058.72
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	243,350,497.80	104,548,590.10	281,348,970.82	629,248,058.72
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	(22,759,713.27)	(22,759,713.27)
2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	243,350,497.80	104,548,590.10	258,589,257.55	606,488,345.45
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	243,350,497.80	104,548,590.10	258,589,257.55	606,488,345.45
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	243,350,497.80	104,548,590.10	258,589,257.55	606,488,345.45
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	1,972,651,826.74	1,972,651,826.74
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	243,350,497.80	104,548,590.10	2,231,241,084.29	2,579,140,172.19

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Улсын төсвийн гүйцэтгэл			/ төгрөгөөр /		
Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,284,441,400.00	1,060,570,751.06	82.57	223,870,648.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,284,441,400.00	1,060,570,751.06	82.57	223,870,648.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,197,163,400.00	1,002,268,751.06	83.72	194,894,648.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	819,737,500.00	694,625,427.00	84.74	125,112,073.00
210101	Үндсэн цалин	489,568,000.00	397,596,082.00	81.21	91,971,918.00
210102	Нэмэгдэл	240,390,000.00	209,159,327.00	87.01	31,230,673.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,160,000.00	19,255,000.00	146.31	-6,095,000.00
210104	Урамшуулал	76,619,500.00	68,615,018.00	89.55	8,004,482.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	102,467,300.00	86,627,562.96	84.54	15,839,737.04
210201	Тэтгэврийн даатгал	69,677,700.00	59,133,467.80	84.87	10,544,232.20
210202	Тэтгэмжийн даатгал	8,197,400.00	6,994,038.62	85.32	1,203,361.38
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,098,700.00	3,467,320.08	84.60	631,379.92
210204	Ажилгүйдлийн даатгал	4,098,700.00	3,391,113.90	82.74	707,586.10
210205	Эрүүл мэндийн даатгал	16,394,800.00	13,641,622.56	83.21	2,753,177.44
2104	Хангамж, бараа материалын зардал	40,086,000.00	33,528,420.00	83.64	6,557,580.00
210401	Бичиг хэрэг	4,308,700.00	4,129,850.00	95.85	178,850.00
210402	Тээвэр, шатахуун	14,836,000.00	12,827,500.00	86.46	2,008,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,016,100.00	2,799,018.00	92.80	217,082.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,308,700.00	4,235,000.00	98.29	73,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,616,500.00	9,537,052.00	70.04	4,079,448.00

2105	Норматив зардал	123,807,600.00	97,361,079.10	78.64	26,446,520.90
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	93,203,300.00	74,520,085.10	79.95	18,683,214.90
210502	Хоол, хүнс	23,129,300.00	15,365,994.00	66.44	7,763,306.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,475,000.00	7,475,000.00	100.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	62,697,000.00	44,871,900.00	71.57	17,825,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	31,530,200.00	20,500,000.00	65.02	11,030,200.00
210602	Тавилга	6,666,800.00	00.00	0.00	6,666,800.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,500,000.00	4,475,000.00	99.44	25,000.00
210604	Урсгал засвар	20,000,000.00	19,896,900.00	99.48	103,100.00
2107	Томилолт, зочны зардал	7,500,000.00	7,083,400.00	94.45	416,600.00
210702	Дотоод албан томилолт	7,500,000.00	7,083,400.00	94.45	416,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,077,900.00	27,408,882.00	91.13	2,669,018.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	23,925,000.00	23,649,624.00	98.85	275,376.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,550,000.00	1,152,000.00	74.32	398,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	129,000.00	43.00	171,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	250,000.00	241,756.00	96.70	8,244.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,300.00	55,000.00	99.46	300.00
210807	Газрын төлбөр	120,000.00	35,132.00	29.28	84,868.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	3,877,600.00	2,146,370.00	55.35	1,731,230.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10790100.00	10762080.00	99.74	28,020.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,790,100.00	10,762,080.00	99.74	28,020.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	87278000.00	58302000.00	66.80	28,976,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	87,278,000.00	58,302,000.00	66.80	28,976,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	87,278,000.00	58,302,000.00	66.80	28,976,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,284,441,400.00	993,026,729.82	77.31	291,414,670.18
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,003,610,400.00	904,689,729.82	90.14	98,920,670.18
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,003,610,400.00	904,689,729.82	90.14	98,920,670.18
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	280,831,000.00	88,337,000.00	31.46	192,494,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	117,278,000.00	88,337,000.00	75.32	28,941,000.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	163,553,000.00			163,553,000.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	163,553,163.61		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	96,009,142.37		

Орон нутгийн төсвийн гүйцэтгэл:

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	69,611,300.00	69,159,920.00	99.35	451,380.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	69,611,300.00	69,159,920.00	99.35	451,380.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	69,611,300.00	69,159,920.00	99.35	451,380.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	62,811,300.00	62,359,920.00	99.28	451,380.00
210301	Гэрэл, цахилгаан	6,212,900.00	5,761,520.00	92.73	451,380.00
210302	Түлш, халаалт	55,598,400.00	55,598,400.00	100.00	0.00
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	1,000,000.00	100.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,800,000.00	6,800,000.00	100.00	0.00
210604	Урсгал засвар	68,000,000.00	6,800,000.00	10.00	61,200,000.00

III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	69,611,300.00	69,159,920.00	99.35	451,380.00
13	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	65,611,300.00	69,159,920.00	105.41	(3,548,620.00)
132001	Орон нутгийн төсвөөс	65,611,300.00	69,159,920.00	105.41	(3,548,620.00)
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	4,000,000.00	0.00	0.00	4,000,000.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 24,246.5 мянган төгрөгийн 9 алдаа, зөрчлийг илрүүлснээс 14,195.3 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 7,109.2 мянган төгрөгийн 6 зөрчилд зөвлөмж өгч, 2,942.0 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага хүргүүлжээ.

3.1 Залруулсан алдаа

Эрүүл мэндийн даатгалын сангаас өмнөх оны санхүүжилтийн авлага 14,195.3 төгрөгийг хүлээн авч бүртгэхдээ мөнгөн гүйлгээний тайланд төсөвт байгууллагын өөрийн орлогоор бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 заалт "үнэн зөв байх;" заалттай нийцэхгүй "үнэлгээ ба хуваарилал" батламж мэдэгдлийг хангахгүй байх тул эрүүл мэндийн даатгалаас санхүүжих санхүүжилтийн дүнгээр бүртгүүлж залруулга хийсэн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 10,051.2 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 19,545.7 мянган төгрөгөөр бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

3.2 Албан шаардлага

Нийцлийн аудитын хүрээнд авч үзсэн Шилэн дансны тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн зохих заалттай холбоотой зөрчлүүд болон байгууллагын төсвийг үр ашиггүй зарцуулсан зөрчилд дараах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн. Үүнд:

- Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас 16,936.9 мянган төгрөгөөр давсан дүнгээр эмийн худалдан авалтыг хийсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 "Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно." заалттай нийцэхгүй "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байх тул албан шаардлага хүргүүлсэн.
- Тус эрүүл мэндийн төв www.shilendans.gov.mn цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 26, зарлагын 12 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 17 шийдвэрийг хугацаа хоцроож мэдээлсэн нь "Шилэн дансны тухай" хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;" заалт, 6 дугаар зүйлийн 6.4.5 "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;" 6.4.8 "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;" заалт болон "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангаагүй, өмнөх аудитын зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байх тул албан шаардлага хүргүүлсэн.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус эрүүл мэндийн төвийн мөрдөж байгаа Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь гүйцэтгэлийн санхүүжилтэд шилжсэнтэй холбоотой болон бусад шинээр гарсан дүрэм, журамтай нийцэхгүй болсон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана." заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинээр гарсан дүрэм, журамтай нийцүүлэн шинэчлэн боловсруулж, мөрдөх.

2. Төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Орон нутгийн өмчийн байрны урсгал засвар хийх зориулалттай зардлаас автомашины засвартай холбоотой 2,500.0 мянган төгрөгийн зардал гаргасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" заалттай нийцэхгүй "үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх

3. Худалдан авах ажиллагааны төлөвлөлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд бараа үйлчилгээний бусад зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ, эмийн зардлыг оруулаагүй баталсан, төсвийн жилийн дундуур төсөвт орсон өөрчлөлтийг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална.", 48 дугаар зүйлийн 48.2.1 "Худалдан авах ажиллагааг батлагдсан төсөвт багтаан хуульд заасан хугацаанд зохион байгуулах;" заалт, Сангийн сайдын 2023 оны А/250 тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 2.11 "Захиалагч цахим системд нийтэлсэн төлөвлөгөөг мөрдөж ажиллах ба энэ журмын 2.12-т заасан үндэслэлээр батлагдсан төлөвлөгөөнд орсон нэмэлт, өөрчлөлтийг холбогдох шийдвэр гарснаас хойш ажлын 10 өдөрт багтаан төлөвлөгөөнд өөрчлөлтийг тусган, батална. Хэрэв холбогдох дээд шатны байгууллага байгаа бол төлөвлөгөөний өөрчлөлтийг түүгээр батлуулахаар цахим системээр илгээж, өөрчлөлтийг баталгаажуулна." гэж заасантай нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Тайлант оны төлөвлөгөөнд туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг төлөвлөх, төсөвт өөрчлөлт орсон тухай бүрд нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлтийг оруулж батлуулж байх.

4. Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийн асуудал

Илрүүлэлт:

2024 онд 1,056,904.1 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын байгууллагаас нэхэмжилснээс 11,176.6 мянган төгрөг хасагдсан нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6 “эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх даатгуулагчийн төлбөрийн тайлан тооцоо, холбогдох баримт бичгийг үнэн зөв, цаг хугацаанд нь гаргаж эрүүл мэндийн даатгалын байгууллагад ирүүлэх;”, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” 05 дугаар тогтоолын 3.1 “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хяналт, санхүүжилт, төлбөр тооцооны программ, цахим системийг бодит цагийн горимд шилжүүлж,..” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хяналт, санхүүжилт, төлбөр тооцооны цахим системийн дотоод хяналтыг сайжруулж, хасагдалтын хэмжээг өмнөх оноос бууруулах.

5. Нягтлан бодох бүртгэлийн ажилтны урамшууллын талаар

Илрүүлэлт:

Сумын Засаг даргын 2024 оны Б/24 дүгээр захирамжаар эрүүл мэндийн төвийн даргад, Эрүүл мэндийн төвийн даргын тушаалаар нярав, нягтлан бодогч нарт зөвхөн санхүүгийн тайлангийн аудитаар “Зөрчилгүй” дүгнэлт авсан гэсэн ганц шалгуураар олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23.2 заалт, Сангийн сайдын 2012 оны 294 дүгээр тушаалаар баталсан журмын 5.1 заалтад заасан шалгуур үзүүлэлт, Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4 заалтад заасан “Үр дүнгийн гэрээний биелэлт, хэрэгжилтийн явц байдалд үндэслэн...”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3-р хавсралт “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 1.2.1 заалтад “төсвийн ерөнхийлөн захирагч нь харьяа байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ, ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагчид;” мөнгөн урамшуулал олгохоор заасантай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн ажилтнуудад урамшуулал олгохдоо аудитын тайланд бичигдсэн болон бусад хяналтын байгууллагаас илрүүлсэн алдаа, зөрчил, өр, авлага, мэдээ, тайлангийн хугацаа, чанар зэрэг үзүүлэлтийг харгалзаж үзэх.

6. Ахмадын сангийн талаар

Илрүүлэлт:

- Тосонцэнгэл сумын эрүүл мэндийн төв нь ахмадын сан байгуулаагүй байгаа нь Ахмадын настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 “Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны

орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр “Ахмадын сан” байгуулах...” гэж заасантай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Ахмадын санг байгууллагын төсөвт тусгаж батлуулах, Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан журмыг мөрдөж ажиллах

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Эрүүл мэндийн даатгалын сангаас авсан өмнөх оны авлагыг төсөвт байгууллагын өөрийн орлогоор бүртгэсэн.	1	14,195.3			1	14,195.3	1	14,195.3		
Дүн	1	14,195.3			1	14,195.3	1	14,195.3		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас автомашины сэлбэг худалдаж авч, зарцуулсан.	1	2,500.0					1	2,500.0
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинээр гарсан дүрэм, журамд нийцүүлэн шинэчлээгүй.	1	-					1	-
Нягтлан бодох бүртгэлийн ажилтнуудад урамшуулал олгохдоо холбогдох шалгуур үзүүлэлтүүдийг харгалзаж үзээгүй.	1	7,551.2					1	7,551.2
Дүн	3	10,051.2					3	10,051.2

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

Шилэн дансны цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлага, төсөв, санхүү, хөрөнгө мөнгө зарцуулахтай холбоотой шийдвэрийг хугацаа хоцроож мэдээлсэн., өмнөх аудитын зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй.	1	-			1	-		
Эм,эмнэлгийн хэрэглэлийн шууд худалдан авалтын дүн ЗГ-аас тогтоосон дээд хязгаараас давсан.	1	-			1	-		
Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд зарим зардлыг орхигдуулж баталсан, батлагдсан төсөвт орсон өөрчлөлтийг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй.	1	-					1	-
Эмнэлгийн тусламж үйлчилгээний гүйцэтгэлийг цахим системд бүрэн, үнэ зөв оруулаагүй, дотоод хяналтыг хангалтгүй хэрэгжүүлснээс нэхэмжилсэн санхүүжилтийг бүрэн авч чадаагүй.	1						1	
Ахмадын санг байгууллагын төсөвт тусгаж, батлуулаагүй байна.	1						1	-
Дүн	5	-			2	-	3	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

№ 145/192270469/

Мөрөн сум

УГА-2025/103/МА-ОА-ТЛЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Тосонцэнгэл сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх аудитаар өгсөн Шилэн дансны мэдээллийг тухай бүр байршуулж байх, зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүйгээс Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 26, зарлагын 12 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 17 шийдвэрийг хугацаа хоцроож мэдээлсэн, өмнөх зөвлөмжийг хэрэгжүүлээгүй нь "Шилэн дансны тухай" хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;" заалт, 6 дугаар зүйлийн 6.1."Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ:" 6.4."Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:" заалтыг хэрэгжүүлээгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал нь албан шаардлага өгөх нөхцөл болно" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийн ил тод байдлыг ханган мэдээллийг тогтоосон хугацаанд бүрэн байршуулах, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 20 - ны өдрийн дотор гаргаж, төрийн аудитын байгууллагын Fas.audit.mn цахим системд оруулж, баталгаажуулах;

2. Цаашид гарсан алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Тосонцэнгэл сумын Эрүүл мэндийн төвийн дарга Ч.Мөнхболор, нягтлан бодогч Н.Отгонбаяр нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  А.ЭРДЭНЭБААТАР

АУДИТОР  Г.ИЧИНХОРЛОО

6724070497



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

№ 46/А 2270469/

Мөрөн сум

КӨА - 2025/03/МА - ӨА ТУС

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Тосонцэнгэл сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны эмийн шууд худалдан авалтын дүн нь "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор тогтоосон шууд худалдан авч болох барааны төсөвт өртгийн дээд хязгаараас 16,936,900 (арван зургаан сая есөн зуун гучин зургаан мянга есөн зуу) төгрөгөөр хэтэрсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 "Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно." заалттай нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, акт тогтоох журам"-ын 4.2.1.9-т "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж завсныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа Засгийн газраас тогтоосон шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарыг баримтлан ажиллаж, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор гаргаж, төрийн аудитын байгууллагын Fas.audit.mn цахим системд оруулж, баталгаажуулах;

2. Цаашид гарсан алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Тосонцэнгэл сумын Эрүүл мэндийн төвийн дарга Ч.Мөнхболор, нягтлан бодогч Н.Отгонбаяр нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

А.ЭРДЭНЗБААТАР

АУДИТОР

Г.ИЧИНХОРЛОО

6724070493